



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 05 дугаар сарын 06
№17 /1215/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠲᠦᠨᠦᠨᠢᠨ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

256.	Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		1167
257.	Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай		1170
258.	Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		1171
259.	Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай		1173

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

260.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 18	1174
261.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 19	1174
262.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 20	1175
263.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 21	1175

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

264.	Журам батлах тухай	Дугаар 241	1176
265.	Дүрэм шинэчлэн батлах, Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 252	1183

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 04 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуульд доор дурдсан агуулгатай 13² дугаар зүйл нэмсүгэй:

“13² дугаар зүйл. Цэргийн тагнуулын байгууллага

13².1. Цэргийн тагнуулын байгууллага нь Монгол Улсын Зэвсэгт хүчний удирдлагыг үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон цэрэг-улс төрийн болон цэрэг-стратегийн тагнуулын мэдээллээр хангах үндсэн чиг үүрэг бүхий цэргийн байгууллага мөн.

13².2. Цэргийн тагнуулын байгууллагыг Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчтай зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газар байгуулж, өөрчилж, татан буулгана.

13².3. Цэргийн тагнуулын байгууллагын даргыг Тагнуулын ерөнхий газрын даргад танилцуулж, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга томилно.

13².4. Цэргийн тагнуулын байгууллагын дүрэм, ажиллах журмыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга болон Тагнуулын ерөнхий газрын даргын хамтарсан тушаалаар батална.

13².5. Цэргийн тагнуулын байгууллага үйл ажиллагаагаа явуулахад энэ хуулийн холбогдох заалтыг дагаж мөрдөнө.”

2 дугаар зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.1. Монгол Улсын тагнуулын байгууллагын тогтолцоо нь тагнуулын төв байгууллага /цаашид “Тагнуулын ерөнхий газар” гэх/, түүний төв, орон нутаг дахь салбар, нэгж болон цэргийн тагнуулын байгууллагаас бүрдэнэ.”

3 дугаар зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн “Цэргийн болон хилийн” гэснийг “Хилийн” гэж өөрчилсүгэй.



4 дүгээр зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “цэрэг-стратегийн тагнуул,” гэснийг, мөн зүйлийн 10.10.6 дахь заалтын “цэрэг-стратегийн болон” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1.14 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.1.17 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Үснэгт, хэсэг, мөр

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 04 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зэвсэгт хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “барилга-инженерийн цэргийн удирдах байгууллага,” гэсний дараа “цэргийн тагнуулын байгууллага,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Зөвшөөрч, үндэслэлтэйгээр
Хүндэтгэн үзүүлсэн

Хүндэтгэн үзүүлсэн үндэслэлтэйгээр 2022 оны 04 сарын 15-ны өдөр

Хүндэтгэн үзүүлсэн үндэслэлтэйгээр
Хүндэтгэн үзүүлсэн

6. Хүндэтгэн үзүүлсэн үндэслэлтэйгээр 7.3 дахь хэсгийн дараа “барилга-инженерийн цэргийн удирдах байгууллага,” гэсний дараа “цэргийн тагнуулын байгууллага,” гэж нэмсүгэй.

7. Энэ хуулийг Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Зөвшөөрч, үндэслэлтэйгээр
Хүндэтгэн үзүүлсэн

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 04 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 9.1.8 дахь заалт:

“9.1.8.цэргийн тагнуулын байгууллага нь олон улсын болон бүс нутгийн цэрэг-улс төрийн байдлыг судалж, Монгол Улсад учирч болзошгүй аюул, заналхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, цэрэг-улс төрийн болон цэрэг-стратегийн тагнуулын мэдээллээр төрийн дээд болон Зэвсэгт хүчний удирдлагыг хангах.”

2/12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт:

“12.1.3.олон улс, бүс нутгийн цэрэг-улс төрийн болон цэрэг-стратегийн байдал, үүсэж болзошгүй цэргийн аюул заналхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, үүнтэй холбоотой мэдээллээр зэвсэгт хүчний удирдлагыг хангахад чиглэсэн хилийн чанадад явуулах цэргийн тагнуулын ажиллагаа;”

2 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “Гадаад тагнуул, сөрөх тагнуул, цэрэг-стратегийн болон хилийн тагнуулын үйл ажиллагааг тагнуулын байгууллага” гэснийг “Гадаад тагнуул, сөрөх тагнуул, эдийн засгийн тагнуул, цэргийн тагнуул, хилийн тагнуулын үйл ажиллагааг эдгээр ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.3, 12.1.4, 12.1.5, 12.1.6 дахь заалтын дугаарыг “12.1.4, 12.1.5, 12.1.6, 12.1.7” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтын “цэрэг-стратегийн болон” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 04 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуульд заасан цэргийн тагнуулын байгууллагын бие бүрэлдэхүүний алба хаах үйл ажиллагаатай холбоотой төсөв, гүйцэтгэх ажилтай холбогдох бие бүрэлдэхүүн, санхүү, дэд бүтэц, барилга байгууламж, материал техникийн хангамж, зэвсэг хэрэгслийг Зэвсэгт хүчний Жанжин штабт шилжүүлэх ажлыг 2022 оны 07 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2 дугаар зүйл. Цэргийн тагнуулын байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн хэмжээ, сүлжээ, цэргийн алба хаагчийн онцгой нөхцөлийн болон хуульд заасан бусад нэмэгдлийн хэмжээг тогтооходоо алба хаагчдын эрх зүйн байдал, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх зарчмыг баримтална.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Үснэгт 1-ийн 1-ийн

2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуульд заасан цэргийн тагнуулын байгууллагын бие бүрэлдэхүүний алба хаах үйл ажиллагаатай холбоотой төсөв, гүйцэтгэх ажилтай холбогдох бие бүрэлдэхүүн, санхүү, дэд бүтэц, барилга байгууламж, материал техникийн хангамж, зэвсэг хэрэгслийг Зэвсэгт хүчний Жанжин штабт шилжүүлэх ажлыг 2022 оны 07 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2 дугаар зүйл. Цэргийн тагнуулын байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн хэмжээ, сүлжээ, цэргийн алба хаагчийн онцгой нөхцөлийн болон хуульд заасан бусад нэмэгдлийн хэмжээг тогтооходоо алба хаагчдын эрх зүйн байдал, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх зарчмыг баримтална.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 02 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 18

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Румын Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дашжамцын Батсайханыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Румын Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лхагвасүрэнгийн Саянаар томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 02 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 19

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Словак Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Нямаагийн Наранбатыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Словак Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дамдины Гансүхийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 02 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 20

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Азербайжан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Равдангийн Болдыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Азербайжан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гомбосүрэнгийн Мөнхбаярыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 02 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 21

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Люксембургийн Их Гүнт Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Одын Очийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Люксембургийн Их Гүнт Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лувсанвандангийн Болдыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 8 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 241

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Газрын тосны тухай хуулийн 7.1.14, Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн 3.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Батлагдсан журмыг хэрэгжүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт тус тус даалгасугай.

3.Газрын тос боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын холбогдох сайд, Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбат, Дорноговь аймгийн Засаг дарга О.Батжаргал нарт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Г.ЁНДОН

Засгийн газрын 2021 оны 241 дүгээр
тогтоолын хавсралт

ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРТ ТӨРӨӨС ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Газрын тос боловсруулах үйлдвэр, түүхий тос дамжуулах хоолой, тэдгээрийн үндсэн технологийн ба дагалдах, туслах байгууламж (цаашид “үйлдвэрийн барилга байгууламж” гэх)-ийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх, олон улсын норм, дүрэм, стандартыг бүртгэх, барилга байгууламжийн ажлын зөвшөөрөл олгох, барилгын болон газрын тос боловсруулах үйлдвэрийн зөвшөөрөл бүхий талбайд явуулах газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд төрөөс дэмжлэг үзүүлэх, бүтээн байгуулалтад оролцох ажиллах хүч, мэргэжилтэн гадаадаас авах,

барилга угсралтад шаардагдах машин механизм, техник, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, түүхий эд, бараа материалын тээвэрлэлт, Газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолойн аюулгүй байдал, харуул хамгаалалттай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмыг мөрдөнө.

Хоёр.Үйлдвэрийн барилга байгууламжийн норм,
дүрэм, стандартыг бүртгэх

2.1.Барилгын асуудал хариуцсан болон стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь үйлдвэрийн барилга байгууламжийн барилгын ажилд баримтлах олон улсын болон гадаад улсын эрх бүхий байгууллагаас баталсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, дүрэм, стандартыг бүртгүүлэх хүсэлтийг дараахь журмаар хянан шийдвэрлэнэ:

2.1.1.олон улсын болон гадаад улсын эрх бүхий байгууллагаас баталсан норм, дүрэм, стандартыг бүртгүүлэх хүсэлтийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээн авснаас хойш 30 хоногт;

2.1.2.олон улсын болон гадаад улсын эрх бүхий байгууллагаас баталсан стандартыг бүртгүүлэх хүсэлтийг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүлээн авснаас хойш 10 хоногт.

2.2.Үйлдвэрийн барилга байгууламжийн барилгын ажилд хэрэглэх олон улсын болон гадаад улсын эрх бүхий байгууллагаас баталсан барилга байгууламжийн норм, дүрэм, стандартыг бүртгүүлэх хүсэлтэд дараахь баримт бичгийг заавал хавсаргана:

2.2.1.олон улсын болон гадаад улсын эрх бүхий байгууллагаас баталсан норм, дүрэм, стандартыг хэрэглэх болсон шалтгаан, шаардлага, хамрах хүрээ, зориулалтыг тусгасан танилцуулга;

2.2.2.барилгын ажилд хэрэглэх олон улсын болон гадаад улсын эрх бүхий байгууллагаас баталсан норм, дүрэм, стандартын жагсаалт болон хуулбар хувь (англи хэлээр).

2.3.Энэ журмын 2.1-д заасан байгууллага нь олон улсын болон гадаад улсын эрх бүхий байгууллагаас баталсан норм, дүрэм, стандартыг бүртгэхдээ дараахь баримт бичгийг шаардахгүй:

2.3.1.бүртгүүлж, хэрэглэх норм, дүрэм, стандартыг гадаадын аль нэг улсын эрх бүхий байгууллагаас худалдан авсан талаарх албан ёсны баримт;

2.3.2.бүртгүүлэх олон улсын болон гадаад улсын эрх бүхий байгууллагаас баталсан норм, дүрэм, стандартын эх хувь, баталгаат орчуулга;

2.3.3.барилгын асуудал хариуцсан болон стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын лавлагаа.

2.4.Барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас энэ журмын дагуу үйлдвэрийн барилга байгууламжийн барилгын ажилд хэрэглэх олон улсын болон гадаад улсын норм, дүрэм, стандартыг бүртгүүлэх хүсэлтийг хянан шийдвэрлэхэд “Журам батлах тухай” Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 107 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилгын үйл ажиллагаанд олон улсын байгууллага, гадаадын барилга байгууламжийн норм, дүрэм, стандартыг бүртгэх, хэрэглэх журам”-ын 2.3.1, 2.3.3, 2.3.4-т заасан мэргэжилтний санал дүгнэлт, мэргэжлийн болон салбарын шинжлэх ухаан, техник, технологийн зөвлөлийн хурлын шийдвэр гаргуулсан байхыг шаардахгүй.

2.5.Энэ журмын 2.1-д заасны дагуу бүртгүүлсэн олон улсын болон гадаад улсын эрх бүхий байгууллагаас баталсан норм, дүрэм, стандартыг үйлдвэр ашиглалтад орох хүртэлх хугацаанд хэрэглэнэ.

2.6.Энэ журамд өөрөөр заагаагүй бол үйлдвэрийн барилга байгууламжийн барилгын ажилд олон улсын болон гадаад улсын эрх бүхий байгууллагаас баталсан норм, дүрэм, стандартыг бүртгэх, хэрэглэхтэй холбоотой харилцааг хууль болон холбогдох журамд заасны дагуу зохицуулна.

Гурав.Үйлдвэрийн барилга,байгууламжийн зураг
төсөл боловсруулах, магадлал хийх

3.1.Үйлдвэрийн барилга байгууламжийн ерөнхий төлөвлөгөөг газрын тосны асуудал эрхэлсэн болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталгаажуулна.

3.2.Үйлдвэрийн барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгаврыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталгаажуулна.

3.3. Үйлдвэрийн барилга байгууламжийн зураг төслийн даалгаврыг гэрээ үйлдсэн хэлээр холбогдох мэргэжлийн зөвлөлөөр хянуулж, дүгнэлт гаргуулсан байна.

3.4. Үйлдвэрийн барилга байгууламжийн эх загвар зураг (эскиз)-ийг монгол хэлэнд хөрвүүлсэн байх ба бусад үе шатны зураг төсөл нь гэрээ үйлдсэн хэлээр байна.

3.5. Үйлдвэрийн барилга байгууламжийн эх загвар зураг (эскиз)-ийг “Дүрэм шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 108 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 5.2-т заасны дагуу баталгаажуулж, хугацааг нэг удаа сунгаж болно.

3.6. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаас олгосон үйлдвэрийн лицензтэй технологийн байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэхийг шаардахгүй.

3.7. Энэ журмын 3.6-д зааснаас бусад барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлын хэсгийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага томилно. Ажлын хэсэгт экспертийн эрх авсан иргэн, хуулийн этгээдийг оролцуулах бөгөөд уг этгээд нь Барилгын тухай хуулиар тавигдах шаардлагыг хангаж, хариуцлага хүлээнэ.

3.8. Үйлдвэрийн барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийхэд “Дүрэм шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 108 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 6.12.6, 6.12.7-д заасныг шаардахгүй.

3.9. Үйлдвэрийн барилга байгууламжийн технологийн нэгдмэл бус бүрдэл хэсгийн зураг төсөлд хэсэгчлэн магадлал хийж болно.

3.10. Үйлдвэрийн барилга байгууламжийн зураг төслийг гэрээ үйлдсэн хэлээр баталгаажуулна.

3.11. Энэ журмаар зохицуулаагүй үйлдвэрийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийхтэй холбогдсон харилцааг Барилгын тухай хууль болон холбогдох журмаар зохицуулна.



Дөрөв. Үйлдвэрийн барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх,
үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулах

4.1. Үйлдвэрийн барилга байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох асуудлыг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналаар Засгийн газар шийдвэрлэнэ.

4.2. Үйлдвэрийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээн авч хянаад үйлдвэрийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг байгуулж ажиллуулна.

4.3. Энэ журмын 4.2-т заасан үйлдвэрийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд холбогдох төрийн захиргааны төв болон төрийн байгууллагын төлөөллийг оролцуулна.

4.4. Энэ журмаар зохицуулаагүй барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулахтай холбоотой харилцааг Барилгын тухай хууль болон холбогдох журмаар зохицуулна.

Тав. Газрын тосны хайгуул, ашиглалтын
үйл ажиллагаа

5.1. Газрын тос боловсруулах үйлдвэр нь газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл авах, сунгах хүсэлтээ газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргах бөгөөд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу бичиг баримтын бүрдлийг хангана.

5.2. Газрын тос боловсруулах үйлдвэр нь Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн 5.3-т заасан гэрээг Засгийн газраар хэлэлцүүлж, Монгол Улсад хамгийн ашигтай байх зарчмыг баримтлан байгуулна.

5.3. Газрын тос боловсруулах үйлдвэр нь газрын тос хайх, ашиглах үйл ажиллагаанд Газрын тосны тухай хуулийн 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18.2, 19, 20, 21, 26, 32, 33, 34, 36 дугаар зүйлд зааснаас бусад зохицуулалтыг мөрдөн ажиллана.

5.4. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд шаардагдах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, туслан гүйцэтгэгч сонгохдоо Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкны данстай, дотоодын хөрөнгө оруулалттай, шаардлага хангасан аж ахуйн нэгжид давуу эрх олгоно.



5.5.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь газрын тосны үйлдвэрийн хүсэлтийн дагуу тухайн талбайд хийгдсэн хайгуулын ажлын анхдагч өгөгдөл, боловсруулалт хийгдсэн өгөгдөл, тайлан, материал, мэдээллийг цахим хэлбэрээр, боломжгүй тохиолдолд бусад хэлбэрээр хуулбарлан өгнө.

5.6.Энэ журмаар зохицуулаагүй газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон бусад харилцааг Газрын тосны тухай хууль болон холбогдох журмаар зохицуулна.

Зургаа.Ажиллах хүч, мэргэжилтэн гадаадаас авах

6.1.Үйлдвэрт ажиллах гадаадын мэргэжилтэн, ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 8.2-т заасны дагуу авсан хөдөлмөр эрхлэх урьдчилсан зөвшөөрөл, гадаадын иргэний хилээр орж ирсэн дардас дарагдсан хуудас, эрүүл мэндийн үзлэгийн хуудсыг үндэслэн олгоно.

6.2.Газрын тос боловсруулах үйлдвэрийн хүсэлтийг үндэслэн гадаадын ажиллах хүч, мэргэжилтэнд зохих визийг Монгол Улсын хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газар, Гадаадын иргэн, харьяатын газар шуурхай олгох арга хэмжээг зохион байгуулна.

6.3.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь гадаадаас ирсэн ажиллах хүч, мэргэжилтэнд хөдөлмөр эрхлэх болон оршин суух зөвшөөрөл олгох асуудлыг хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор шийдвэрлэнэ.

6.4.Боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь үйлдвэрт ажиллах инженер, техникийн ажиллагсдыг бэлтгэх, мэргэшүүлэх, дадлагажуулахад дэмжлэг үзүүлнэ.

Долоо.Үйлдвэрийн болон түүхий тос дамжуулах хоолойн барилга байгууламжид ашиглах техник, тоног төхөөрөмж, түүхий эд, бараа материалын тээвэрлэлт

7.1.Үйлдвэрийн барилга байгууламжийн угсралтад шаардлагатай машин механизм, техник, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, түүхий эд, бараа материалыг хил дамжуулан тээвэрлэх асуудлаар гадаад харилцааны болон зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дэмжлэг үзүүлж ажиллана.



7.2.Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь үйлдвэрийн барилга байгууламжийн барилга угсралтад ашиглах машин механизм, техник, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, түүхий эд, бараа материалыг улсын хилээр тэргүүн ээлжид нэвтрүүлж, тээвэрлэх арга хэмжээ авна.

7.3.Төмөр замын байгууллага нь үйлдвэрийн болон түүхий тос дамжуулах хоолойн барилга байгууламжийн барилга угсралтад ашиглагдах машин механизм, техник, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, түүхий эд, бараа материалыг захиалгын дагуу тэргүүн ээлжид тээвэрлэх арга хэмжээ авна.

7.4.Газрын тос боловсруулах үйлдвэр нь холбогдох тооцоо, судалгаанд үндэслэн овор хэмжээ ихтэй, задлах боломжгүй, хүнд ачааг тээвэрлэх маршрут, бүрэлдэхүүнийг авто замын ашиглалт хариуцсан болон цагдаагийн байгууллагатай хамтран тогтооно. Шаардлагатай тохиолдолд тээвэрлэлтийн аюулгүй байдал, харуул хамгаалалтыг орон нутгийн цагдаагийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

Найм.Нэгжийн удирдлагын дэмжлэг

8.1.Үйлдвэрийн барилга байгууламжийг барих, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулахад тухайн нэгжийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг дарга дараахь дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана:

8.1.1.Засаг дарга нь Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг харьяа байгууллага, олон нийтэд сурталчлах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

8.1.2.нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга нь газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга байгууламжийг барих болон газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх аливаа хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

8.1.3.холбогдох бусад.

Ес.Аюулгүй байдал, харуул хамгаалалт

9.1.Үйлдвэрийн барилга байгууламжийн аюулгүй байдал, харуул хамгаалалтыг үйлдвэр ашиглалтад орох хүртэлх хугацаанд улсын төсвийн хөрөнгөөр, үйлдвэр ашиглалтад орсноос хойш гэрээт хамгаалалтын хүрээнд дотоодын цэрэг гүйцэтгэнэ.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 8 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 252

Улаанбаатар
хот

Дүрэм шинэчлэн батлах, Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 23.1.3, 23.1.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Хөгжлийн банкны дүрмийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Татан буулгахаар шийдвэрлэгдсэн “Ди Би Эм ассет менежмент” ХХК, “Ди Би Эм Лизинг” ХХК-ийн үйл ажиллагааг сэргээсүгэй.

3.Энэ тогтоолын 2-т заасан компанийг татан буулгах ажиллагааг зогсоож, үйл ажиллагааг нь хэвийн үргэлжлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (С.Наранцогт)-д даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм шинэчлэх, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 129 дүгээр тогтоолын 1 дэх заалт, “Монгол Улсын Хөгжлийн банкны охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 155 дугаар тогтоолын 1, 2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

Засгийн газрын 2021 оны 252 дугаар
тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрмийн зорилго нь Монгол Улсын Хөгжлийн банк (цаашид “Банк” гэх)-ны үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, хяналт, шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.



1.2.Дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

Хоёр.Банкны оноосон нэр

2.1.Банкны оноосон нэрийг монгол хэлээр “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК (товчоор “МУХБ”), англи хэлээр “Development Bank of Mongolia” LLC (товчоор “DBM”) гэнэ.

Гурав.Банкны тэмдэг, бэлгэдэл

3.1.Банк нь тогтоосон журмын дагуу баталсан тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

3.2.Банк өөрийн бэлгэдэлтэй байх бөгөөд түүний загвар, тодорхойлолтыг Банкны төлөөлөн удирдах зөвлөл батална.

Дөрөв.Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө

4.1.Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 1,000,000,000,000 (нэг их наяд) төгрөг байх бөгөөд нэг бүр нь 100,000 (нэг зуун мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,000,000 (арван сая) ширхэг энгийн хувьцаанд хуваагдана.

Тав.Банкны үйл ажиллагаанд баримтлах
үндсэн чиглэл

5.1.Банк нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 5.1-д заасан зорилгын хүрээнд дараахь үндсэн чиглэлийг баримтлан ажиллана:

5.1.1.олон улсын жишигт нийцсэн санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх;

5.1.2.гадаад худалдааны эргэлтийг сайжруулах, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох төсөл, хөтөлбөрийг дэмжих;

5.1.3.олон улсын санхүүгийн байгууллагатай харилцан ашигтай хамтран ажиллах;

5.1.4.санхүүгийн хэрэгцээг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх тогтолцоог бүрдүүлж банкны ашигт ажиллагааг хангах.

5.2.Банкны нэгжүүд нь чиг үүргийн хувьд хоорондоо уялдаатай, тэнцвэртэй байх зарчмын дагуу зохион байгуулагдана.

5.3.Банкны үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрсдэлийн удирдлагын хараат бус, бие даасан үйл ажиллагааны тогтолцоонд үндэслэн хэрэгжүүлнэ.

5.4.Хүний нөөцийг мэргэжлийн өндөр ур чадвар, дадлага туршлага бүхий ажилтнаар бүрдүүлэх ба олон улсад хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүний нөөцийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Зургаа.Банкны үйл ажиллагаа

6.1.Банк нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд заасан үйл ажиллагаа эрхэлнэ.

6.2.Банк нь өөрийн эрхлэх үйл ажиллагааны хүрээнд гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцаж, хамтран ажиллах гэрээ, хэлцэл байгуулна.

6.3.Банк нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан дунд, урт хугацааны стратеги төлөвлөгөө, тухайн жилийн бизнес төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулна.

6.4.Банк нь үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор шаардлагатай мэдээллийг хуульд заасны дагуу нийтэд мэдээлж, эрх бүхий байгууллагад гаргаж өгөх ба холбогдох журмыг гүйцэтгэх захирал батална.

6.5.Үйл ажиллагааны үр дүнгийн гүйцэтгэлийг Банкны санхүүгийн үр дүн болон санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн эдийн засаг, нийгэмд үзүүлж буй нөлөөллийг харгалзан жил бүр дүгнэнэ.

6.6.Банкны охин компани нь зээл авах, эх үүсвэр татан төвлөрүүлэх, санхүүжилт олгох, хөрөнгө байршуулах, удирдах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Банкнаас өгсөн чиглэлийг баримтална.

Долоо.Банкны үйл ажиллагаанд хориглох зүйл

7.1.Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хязгаарлалтаас гадна Банк дараахь үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

7.1.1.хууль тогтоомж болон Банкны дотоод журамд заасны дагуу өөрийн банкны ажилтанд санхүүгийн тусламж, дэмжлэг үзүүлэхээс бусад тохиолдолд иргэн, хуулийн этгээдэд буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлэх;

7.1.2.улс төрийн нам, эвсэл, хуулийн этгээд, иргэн болон бусад аливаа этгээдэд хандив өгөх.

Найм.Төлөөлөн удирдах зөвлөл

8.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 19.1-д заасан төлөөллөөс бүрдэх бөгөөд Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

8.2.Төлөөлөн удирдах зөвлөл нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 9.1-д заасан зээл авах, 13.1-д заасан үнэт цаас гаргах болон өөрийн хөрөнгийн 0.6 хувиас дээш үнийн дүнтэй гэрээ, хэлцэл хийх шийдвэрийг гаргана.

8.3.Гүйцэтгэх захирлаас Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 11.1, 14.1-д заасан үйл ажиллагаатай холбогдох гэрээ, хэлцэл хийхэд энэ дүрмийн 8.2-т заасан хязгаарлалт хамаарахгүй байж болох бөгөөд үүнийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд тусгана.

8.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 19.2, 19.3-т заасны дагуу томилж, чөлөөлнө.

8.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн 3 сараас дээш хугацаагаар эрх, үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, эсхүл хууль тогтоомж болон энэ дүрмийн 8.6-д заасан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл нас барсан бол түүнийг хугацаанаас нь өмнө чөлөөлнө. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх асуудлыг хувьцаа эзэмшигч шийдвэрлэнэ.

8.6.Хувьцаа эзэмшигчээс эрх олгосон этгээд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнтэй гэрээ байгуулж жил бүр дүгнэнэ.

8.7.Энэ дүрмийн 8.6-д заасан гэрээнд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний эрх, үүрэг, хариуцлага, баталгааны талаар тусгана.

8.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдэд олгох урамшууллын хэмжээг хувьцаа эзэмшигч тогтооно.

8.9.Банкны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах зайлшгүй шаардлагыг харгалзан гүйцэтгэх захирал, тэргүүн дэд захирал, дэд захирал болон газрын захирлыг сонгон шалгаруулж томилох хүртэлх хугацаанд тэдгээрийн үүрэг гүйцэтгэгчийг хувьцаа эзэмшигчийн саналыг үндэслэн төлөөлөн удирдах зөвлөл томилж болно.

8.10.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг албан томилолтоор ажиллуулах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гаргана.

8.11.Төлөөлөн удирдах зөвлөлийн тухайн жилийн ээлжит болон ээлжит бус хурлын гуравны нэгээс дээш хувьд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх үндэслэл болно.

8.12.Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээс бусад гишүүн үндсэн ажлаасаа чөлөөлөгдсөн, халагдсан бол тухайн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох үндэслэл болно.

8.13.Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Хурал нь ээлжит болон ээлжит бус байна.

8.14.Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлыг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 20.3-т заасны дагуу сард нэгээс доошгүй удаа хуралдуулна.

8.15.Банкны үйл ажиллагаатай холбоотой шуурхай шийдвэрлэх асуудал гарсан тохиолдолд гүйцэтгэх удирдлагын саналыг үндэслэн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.

8.16.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

8.17.Банкны зохион байгуулалтын бүтэц, стратеги төлөвлөгөө, төсөв батлах, гүйцэтгэх удирдлагыг томилох, чөлөөлөх, санхүүгийн тайлан хэлэлцэхээс бусад асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн эчнээ санал хураалтаар шийдвэрлэж болно.

8.18.Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 20.3-т заасныг зөрчсөн нь төлөөлөн удирдах зөвлөлийн даргад хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

8.19.Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 7.1.6-д заасны дагуу хамтын удирдлагад үндэслэсэн байна.

8.20.Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд түүнд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурна.

8.21.Төлөөлөн удирдах зөвлөл нь албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

8.22.Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг Банкны жил бүрийн төсөвт тусгана.

8.23.Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ аудит, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороотой байх бөгөөд эрсдэлийн хороотой байж болно.

8.24.Төлөөлөн удирдах зөвлөл нь хороодын ажиллах журам, Банкны үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээ, зээлийн төвлөрлийн эрсдэлийн арга, аргачлалуудыг батална.

Ес.Банкны гүйцэтгэх удирдлага

9.1.Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 21.2-т заасны дагуу Банкны гүйцэтгэх удирдлагыг гүйцэтгэх захирал хэрэгжүүлж, Банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

9.2.Гүйцэтгэх захирал нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 21.5, 21.6-д заасан бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргах бөгөөд шийдвэр нь тушаал хэлбэртэй байна.

9.3.Гүйцэтгэх захирал нь энэхүү дүрмийн 8.2-т зааснаас бусад гэрээ, хэлцэлд хамаарах төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх, баталгаа, батлан даалт гаргах, валют худалдах, худалдан авах, хадгалуулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээ үзүүлэх, экспорт, импортын санхүүжилт хийх, төлбөрийн чадварыг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор богино, дунд хугацаатай санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх зэрэг шийдвэрийг гаргана.

9.4.Тэргүүн дэд захирал, дэд захирал, газрын захирлыг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 21.3-т заасан журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл томилох бөгөөд тэдэнтэй гүйцэтгэх захирал гэрээ байгуулна.

9.5.Тэргүүн дэд захирал, дэд захирал, газрын захиралд тавигдах шаардлага, тэдгээрийг сонгон шалгаруулахтай холбоотой зохицуулалтыг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 20.1.4-т заасан журамд тусгана.

9.6.Хууль, энэ дүрэмд төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэхээр зааснаас бусад асуудлаар гүйцэтгэх захирал Банкийг төлөөлж, гэрээ,

хэлцэл байгуулах шийдвэр гаргана. Гүйцэтгэх захирлын түр эзгүйд, түүний эрх олгосноор тэргүүн дэд захирал энэхүү эрхийг эдэлнэ.

9.7.Тэргүүн дэд захирал, дэд захирал, газрын захирал нь үйл ажиллагаандаа хууль тогтоомж, Засгийн газар, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, тэдгээрт нийцүүлэн гаргасан гүйцэтгэх захирлын тушаал, үүрэг, даалгаврыг удирдлага болгоно.

9.8.Гүйцэтгэх захирлын дэргэд түүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах, зөвлөх чиг үүрэг бүхий Захирлуудын зөвлөл ажиллана.

9.9.Захирлуудын зөвлөлийн бүрэлдэхүүнийг гүйцэтгэх захирал тогтооно.

Арав.Эрх бүхий албан тушаалтан

10.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, тэргүүн дэд захирал, дэд захирал, газрын захирал, мэргэжлийн хороодын гишүүд, ерөнхий нягтлан бодогч, аудитор нь Банкны эрх бүхий албан тушаалтанд хамаарна.

Арван нэг.Банкны зохион байгуулалтын бүтэц

11.1.Банкны зохион байгуулалтын бүтцийг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 20.1.5-д заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл батална. Зохион байгуулалтын бүтцийн төслийг төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд гүйцэтгэх захирал танилцуулна.

11.2.Банк нь актив, пассив хөрөнгийн, зээлийн, эрсдэлийн удирдлагын мэргэжлийн хороодтой байж болно. Хороодын бүрэлдэхүүнийг гүйцэтгэх захирал, үйл ажиллагааны болон шийдвэр гаргах журмыг төлөөлөн удирдах зөвлөл тус тус батална.

11.3.Хороод нь холбогдох тооцоо, судалгаа, шинжилгээнд тулгуурлан хууль зүйн үндэслэл бүхий шийдвэрийг гишүүдийн дийлэнх олонхын саналаар гаргана. Хорооны шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гүйцэтгэх захирал нэг удаа буцаах эрхтэй.

11.4.Зээл авах, үнэт цаас гаргах, төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх, баталгаа, батлан даалт гаргах, хөрөнгө байршуулах, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авахтай холбогдох асуудлаар мэргэжлийн хороод шийдвэрээ гаргаж, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захиралд хүргүүлсэн байна.

Арван хоёр.Хяналт, шалгалт

12.1.Банкны үйл ажиллагаанд Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 25.2, 25.3-т заасны дагуу Монголбанк, Засгийн газар хяналт, шалгалт хийнэ.

Арван гурав.Дотоод аудит

13.1.Банк нь дотоод аудитын нэгжтэй байх бөгөөд дотоод аудитын нэгж нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 26.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

13.2.Дотоод аудитын нэгж нь өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар аудит хийж, дүгнэлтээ зөвлөмжийн хамт төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлнэ.

Арван дөрөв.Хянан шалгагч

14.1.Банк нь хянан шалгагчтай байх бөгөөд хянан шалгагчийг гүйцэтгэх захирал томилж, чөлөөлнө.

14.2.Хянан шалгагч нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 27.1-д заасан үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийнэ.

14.3.Хянан шалгагч нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 27.2-т зааснаас гадна дараахь эрхтэй байна:

14.3.1.хяналт, шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Банкны бусад нэгжийн албан тушаалтныг татан оролцуулах, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах;

14.3.2.хяналт, шалгалт хийх объектод саадгүй нэвтрэх.

14.4.Хянан шалгагч дараахь үүрэгтэй байна:

14.4.1.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

14.4.2.хяналт, шалгалт хийхдээ аливаа байгууллага, албан тушаалтан, иргэний ашиг сонирхол, нөлөөнд автахгүй, хараат бусаар хэрэгжүүлэх;

14.4.3.хяналт, шалгалтын тайлан мэдээ, санал, дүгнэлтийг үнэн зөв, бодитой гаргах.

14.5.Хянан шалгагч нь үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд түүнд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

Арван тав.Банкны санхүү, тайлан

15.1.Банк нь хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Гүйцэтгэх захирал компанийн нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна.

15.2.Гүйцэтгэх захирал нь хувьцаа эзэмшигчид дараахь тайлан мэдээллийг гаргаж хүргүүлэх үүрэгтэй:

15.2.1.жилийн орлогын болон хөрөнгийн төсвийг санхүүгийн жил эхлэхээс өмнө бэлтгэж, хувьцаа эзэмшигчдэд илгээх;

15.2.2.хувьцаа эзэмшигчид болон тэдгээрийн эрх олгосон төлөөлөгчдөд Банкны тайлан тооцоонд, нягтлан бодох бүртгэлд хяналт, шалгалт хийх, өөрийн зардлаар хувилах, баримт авах боломж олгох;

15.2.3.хувьцаа эзэмшигчдийг шаардсан тухай бүрд нь Банкны менежментийн болон санхүүгийн мэдээллээр хангах;

15.2.4.банкны улирал тутмын, жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан болон хувьцаа эзэмшигчээс шаардсан мэдээллийг, хүссэн хэлбэрээр (файлаар, хэвлэмлээр, факсаар, и-мэйлээр гэх мэт) гаргаж хүргүүлэх;

15.2.5.тайлант хугацаанд Банкны эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны үр дүн болон бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн талаарх танилцуулга;

15.2.6.тайлант хугацаанд эрх бүхий албан тушаалтанд олгосон шагнал урамшуулал, удирдлагын зардлын хэмжээ.

Арван зургаа.Бусад

16.1.Энэ дүрмээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай, Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

---ооо---



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.75

Индекс: 200003